

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ТҮҮХ

Шарын голын нүүрсний уурхай нь ЗХУ (хуучин нэрээр)-ын техник эдийн засгийн тусламжтайгаар 1965 оны 4-р сарын 6-нд жилдээ 1.1 сая тонн нүүрс олборлож, 5.0 сая шоо метр хөрс хуулах хүчин чадалтайгаар анх байгуулагдсан. 1981 оноос хүчин чадлыг өргөтгөн жилдээ 10 сая.шоо метр хөрс хуулж, 2.0-2.5 сая.тн нүүрс олборлохоор техник-технологио өөрчлөн, тоног төхөөрөмжүүдээ шинэчлэн суурилуулсан.

Хувьцаа эзэмшигчдийн 1995 оны 1-р сарын 21-ний өдрийн хуралдаанаар 723,138.9 мянган төгрөгийн дүрмийн сантайгаар “Шарын гол” ХК болон зохион байгуулагдсан юм.

Нийт хөрөнгийн 80 хувь буюу 578,511.1 мянган төгрөгийн хөрөнгийг төрийн өмчийн харъяалалд үлдээж 20 хувь буюу 144,627.8 мянган төгрөгийн хөрөнгөнд ноогдох 1,446,278 ширхэг хувьцааг хөрөнгийн биржээр арилжаалан 3,738 хувьцаа эзэмшигчтэй хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсан.

2003 онд Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчийн мэдлийн хувьцааг хувьчилж 100% хувийн өмчит компани болсон.

Тус уурхай нь ил аргаар ашиглалт явуулдаг, Монгол улсын эрчим хүчний нүүрсний томоохон уурхайн нэг. Үйлдвэрийн гол хэрэглэгчид нь Дархан, Эрдэнэт, Сэлэнгийн дулааны цахилгаан станцууд юм.

Манай улсын эрчим хүчний нүүрс олборлодог эхний 3 том уурхайн сүүлийн 10 жилийн нүүрс олборлолтын хэмжээ /мянган тонн/

	2000	2001	2002	2003	2004
Багануур	3,066.0	3,140.5	3,049.3	3,045.7	2,711.0
Шивээ овоо	603.3	793.2	899.0	941.3	1,308.7
Шарын гол	709.0	676.8	693.6	664.9	678.8

	2005	2006	2007	2008	2009
Багануур	2,811.4	2,804.4	2,794.3	3,000.4	3,005.8
Шивээ овоо	1,200.3	1,306.7	1,415.0	1,450.6	1,400.0
Шарын гол	710.5	514.7	545.7	548.3	420.6

Хүснэгт 1. Гурван том уурхайн нүүрс олборлолтын хэмжээ /мян.тн/




График 1. Гурван том уурхайн нүүрс олборлолтын хэмжээ /мян.тн/

Тус уурхай нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед ОХУ-д үйлдвэрлэгдсэн 2 СБШ-200Н 9 ЗСБШ-200-60, СБР-160 маркийн өрмийн машин, 4-10

шоо метрийн багтаамж бүхий шанагатай ЭКГ-4у, ЭКГ-5 А, ЭКГ -8 И , ЭШ-6/45, ЭШ-10/70 маркийн гинжит болон алхагч экскаваторууд , 1000-1100 морины хүчтэй ТЭМ-1, ТЭМ-2 маркийн илчит тэрэг, 60-105.0 тоннын даацтай 7BC-60, 2BC -105 маркийн вагон самосвалууд, 27-40 тоннын даазтай Белаз-540, Белаз-548 маркийн автосамосвалууд , ДЭТ-250 , Т-170 маркийн бульдозер зэрэг уулын хүчирхэг техник тоног төхөөрөмжүүдийг үе шаттайгаар нэвтрүүлж үйлдвэрлэл явуулж ирсэн юм.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн ба уул уурхайн шинэ дэвшилтэт техникүүд бий болж гадаад харилцаа өргөжсөнөөр 1992 оноос эхлэн Япон улсад үйлдвэрлэсэн “Коматцу” маркийн бульдозер, Англи-Хятадын хамтарсан үйлдвэрийн “Терекс” маркийн өөрөө буулгагч өндөр даацын автомашин, АНУ-ын Caterpillar пүүсийн 6 шоо метр шанаганы багтаамжтай авто ачигч, 769 D маркийн 40 тоннын даацтай КАТ автосамосвал, дугуйт бульдозер, авто грейдер зэрэг орчин үеийн өндөр чадамжтай техникүүд ашиглах болсон юм.

2010 онд компанийн хувьцааны томоохон багцыг “Firebird management” компани худалдан авч эзэмшиснээр томоохон хөрөнгө оруулалтуудыг хийсэн. Тус ондоо “Firebird management” компаниас хувьцаанд хөрвөх зээлийн санхүүжилт авч, JORC нөөцийн программ болон компанийн засаглалыг сайжруулах, due diligence хийх ажлуудыг зохион байгуулсан.

2011 онд СЗХ-ны шийдвэрээр 5,4 тэрбум төгрөгийн хөрвөх зээлийн санхүүжилтийг 1,292,596 ширхэг хувьцаанд хөрвүүлснээр компанийн нийт гаргасан хувьцаа 8,523,885 ширхэг болж нэмэгдсэн байна.

Хөрвөх зээлийн санхүүжилтийн үр дүнд 2011 оны 3-р сард компани JORC стандартаар хийгдсэн хайгуулын ажлын тайланг хүлээн авсан ба уг тайланд компанийн нөөцийн хэмжээ 376 сая тонн болж нэмэгдэн, нүүрсний чанарын хувьд сайн чанарын эрчим хүчний нөөц болох нь тогтоогдсон. Уг нөөцийг ил уурхайн хэлбэрээр, харьцангуй бага өртгөөр олборлох боломжтой байгаа нь мөн компанийн нэгэн том амжилт болсон.